



## ОРХОН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 12/12

Эрдэнэт

### Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх “Аймгийн хэмжээнд төр, сүм, хийдийн харилцааг зохицуулах зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Үйл ажиллагааны тайланг жил бүрийн IV улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг Зөвлөлд даалгасугай.

3. Аймгийн нутаг дэвсгэрт сүм, хийд, шашны байгууллага байгуулж үйл ажиллагаа явуулах журмыг боловсруулж, захиргааны ерөнхий хуульд заасны дагуу холбогдох материалыг бүрдүүлж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар батлуулан, Хууль зүй дотоод хэргийн яаманд бүртгүүлэх ажлыг 2023 оны I улиралд багтаан зохион байгуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Бодлого төлөвлөлт, хууль эрх зүйн хэлтэс, аймгийн хэмжээнд төр, сүм, хийдийн харилцааг зохицуулах зөвлөлд тус тус даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Ээлжит XII хуралдааны 12 дүгээр тогтоолын хавсралт



## ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
- Гишүүд:
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хорооны дарга
  - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн хөгжлийн хорооны дарга
  - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Бодлогын хэрэгжилт, иргэний оролцооны хэлтсийн дарга
  - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
  - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
  - Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
  - Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
  - Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
  - Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
  - Аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв, журам хамгаалах тасгийн дарга
  - Тагнуулын Ерөнхий газрын Орхон аймаг дахь газрын тухайн асуудал хариуцсан ажилтан
  - Аймгийн Татварын хэлтсийн ААН хариуцсан татварын улсын байцаагч
  - Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн хяналтын улсын байцаагч
  - Гадаадын иргэн харьяатын газрын Хойд бүсийн газрын Орхон аймаг дахь төлөөлөгч
- Нарийн бичгийн дарга: - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны Хурлын зөвлөлүүд хариуцсан мэргэжилтэн